БАТЛАВ.
БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х.БАТЖАРГАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН "СПОРТ ЗААЛНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ"
ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

УТ2601502079 **2026.01.30**

№	Тоног төхөөрөмж		Дараах техникийн үзүүлэлт хангасан (эсхүл түүнтэй дүйцэх)	Тоо, ширхэг
	БАГЦ-1: ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН			
1	Сагсан бөмбөгийн иж бүрдэл	Самбар	* Тэгш өнцөгтэй гадаргуутай, сайжруулсан хуванцар, бэхжүүлсэн хуванцар, бэхжүүлсэн шил, эсвэл шилэн хуванцар материалаар, гэрэл гялбахгүй байхаар хийгдсэн байна. * Хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байх бөгөөд түүний ирмэг нь хамгаалах бүрхүүлтэй байна. * Хананы бэхэлгээтэй, хананд байрлах, хос самбар байна. * Самбарын тулгуурт хамгаалах зөөлөвч хийнэ.	30
		Хэмжээ	* L1800 x W1050 мм * Самбарын зузаан 3-5 см байна.	
		Цагираг	* 45 см диаметртэй байх ба материал нь төмөр, улбар шар буюу улаан өнгөтэй, тор тогтоох нүхнүүдтэй, тортой, хүзүүвчиндээ пүрштэй, самбарт тогтоох нүхнүүд болон боолттой байна.	
		Сагсны бөмбөг	* Синтетик лидерин үнэргүй, гадаргуу нь оёдолгүй, наалттай, дотор хэсгээрээ резинэн эдлэлээр хийгдсэн, улбар шар өнгөтэй. MNS664 (нэг иж бүрдэлд 3 ш бөмбөг) * Бөмбөгний диаметр 650 мм, 260 гр жинтэй, доторхи даралт нь 0.3-0.325 kgf/см.	
2	Заалны турник		* Хананд байрлуулдаг, авирч гардаг, дүүжлэгддэг, төмөр * Хэмжээ: Өндөр 2.2-2.5м, Өргөн нь 2.3м	32
3	Волейболын шон, торны комплекс	Волейболын шон:	* Доошоо 40 см орох суурьтай байх ба дугуй цилиндр хэлбэртэй төмөр, өндрийн түвшинг хялбар өөрчлөх боломж бүхий тор татах хос төхөөрөмж байна. * Шонгийн өндөр нь шалны түвшнөөс дээш 2550 мм хүртэл сунах боломжтой торны өндрийг тааруулахын тулд 800 мм зайд дээш доош болгох хялбар механизмтай байна. * Шонгийн суурь: Шонг шал буюу газарт бэхлэх ба төмөр олс, татуурга, хүндрүүлэгчгүйгээр тогтоож түүнийг зөөлөн материалаар бүрнэ. * Шонг тогтоогоогүй үед нүхийг заавал таглана.	30

		Тор:	* Хар өнгийн 0.3 мм хүртэл диаметртэй мяндсан, олсон утсаар шоо дөрвөлжин сүлжиж хийнэ. * Шоо дөрвөлжин нүд нь 100мм х 100мм эсвэл 45мм х 45мм хэмжээтэй байж болно. * Торны дээд хүрээг 70мм хүртэл, доод хүрээг 50мм хүртэл өргөнтэй цагаан өнгийн материалаар эмжиж хийнэ. * Хэмжээ нь: L9500-10000мм х W1000мм. * Өндөр хэмжигч нь цагаан өнгөтөй, сунадаг, дээрээ хэмжээстэй байх бөгөөд хөнгөн байна. * Хязгаарлагч антен: Хуванцар уян хатан шинж бүхий торонд хялбар бэхлэх боломжтой урт нарийхан саваа хэлбэртэй байх ба торноос дээш агаарын орон зайд тоглолтын талбайг тодорхойлох чиг үүрэг бүхий хэрэглэл.	
	ДҮН			**92**
	БАГЦ-2: ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ			
4	Вандан сандал /спортын/	Их бие	* Сайн чанарын модоор хийсэн хүүхдэд харшил өгөхгүй, элдэв янзын үнэргүй сайн чанарын цайвар шаргал өнгийн будгаар будсан. Сандлын хөлийг тавцангийн материалтай ижил материалаар хийсэн байх бөгөөд хөдөлгөөнгүй бэхэлсэн байна.	501
		Хэмжээ	* L2000xW450xH400 мм	
5	Онооны самбар		* Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны хананд өлгөгдөх зориулалттай. Багуудын оноо болон шүүгчийн шүүлтийг үзэгчдэд ил тод харуулах, тоглогчдын тоглох идэвхийг сайжруулах, спорт заалны өнгө үзэмжийг нэмэгдүүлэхүйц өнгө ялгарал сайтай асдаг сүүлийн үеийн лед дэлгэцтэй байх. * Доргилтоос хамгаалагдсан, 100 м хүртэлх зайд утасгүйгээр удирдах удирдлагатай, дотор болон гадаа талбайд ашиглах боломжтой. * Мөн гар утасны программаар удирдаж болно. * Огноон цаг харуулах горим: Цаг минут, гараг, байгууллага, сургууль, ивээн тэтгэгчийн нэр, орчны температур. * Тэмцээнээс бусад үед дэлгэц дээр сар, өдөр, цаг, минут /бусад/-ийн мэдээлэл гарч байх. Монгол, англи үсгийн фонтой байна. * Жин: 40 кг хүртэл. * Хэмжээ: L1900мм х W1300мм, * Тэжээл, чадал: 220волт, 600ватт. * Холболтын төрөл: Утасгүй холболт. * Дэлгэцийн төрөл: P10 LED. **Үндсэн горимууд, тэдгээрийн мэдээлэл:** * Багуудын оноо - Багуудын нэрс (Монгол, Англи фонтоор) * Үндсэн цаг: Тоглолтын үе - Довтолгооны секунд (24, 14-н сонголттой, долийн нарийвчлалтай. Шаардлагагүй тохиолдолд унтрааж болно) * Багуудын алдаа - Багуудын завсарлага - Хосоор байж болно. Хос үед 5х5 дээр ижил мэдээлэл гаргана. 3х3 дээр тусдаа удирдагдаж ажиллана. * Шийдний 24-н самбар дэмжинэ	35
	ДҮН			**536**
	Нийт дүн			**720**

oOo